



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/192

Бат-Өлзий сум

“Мал мах-2022” нэгдсэн арга хэмжээ
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.10 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Мал мах-2022” нэгдсэн арга хэмжээг суманд зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)
Гишүүд: Д.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад)
П.Аюушжав (Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч)
Н.Түвшин (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
Э.Буянтогтох (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
М.Мягмаржав (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)
Багийн Засаг дарга нар
Р.Даваасүрэн (Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)
Б.Батбилэгт (“Хустын рашаан” Мал эмнэлгийн захирал)
П.Содномбалжир (“Хутагт уулын өгөөж” Мал эмнэлгийн захирал)

2. “Мал мах-2022” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө гарган 2022 оны 11 дүгээр сарын 23-ны дотор батлуулж, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН